



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар A/110

Хужирт сум

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны  
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 221 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/376 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангудалын нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



Сумын Засаг даргын 2020 оны  
12 дугаар сарын 12-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг даргын Орлогч  
Нарийн бичгийн дарга: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Д.Уранчимэг – Санхүүгийн албаны дарга  
Д.Мөнхбат- Бэлчээр, газар тариалангийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн  
Т.Сундуйбаяр- Мал эмнэлгийн тархвар зүйч  
Б.Пагамдулам 1 дүгээр багийн Засаг дарга  
Д.Батбаян 2 дугаар багийн Засаг дарга  
Д.Галиндэв 3 дугаа багийн Засаг дарга  
Ц.Амгалан 6 дугаар багийн Засаг дарга

--оо--

Сумын Засаг даргын 2021 оны  
....-р сарын ....-ны өдрийн ... –р  
захирамжийн ....-р хавсралт

**ХУЖИРТ СУМЫН 2021-2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН  
БЭЛТГЭЛ ХАНГАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хийх ажил	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага.
<b>Нэг :Удирдлага зохион байгуулалтын талаар</b>		
1. Хөдөө аж ахуйн 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах	9 дүгээр сарын 01-ны дотор	ХАА-н тасгийн мэргэжилтэн С.Самдан
2. Хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, шалгах хүлээн авах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	10 дугаар сарын 10-ны дотор	Засаг даргын орлогч Б.Дэмбэрэл
3. Сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүг бэлтгэх тоо хэмжээнд хяналт тавьж аж ахуйн нэгж иргэдийн тариалсан ногоон тэжээлээр орон нутагтаа нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	9,10-р саруудад	Сумын ЗДТГ, ХААТ, Б3Дарга нар
4. Малчдын хувийн бэлтгэлийг хангахад анхаарч цаг агаарын мэдээ, мэдээлэлийг утас болон цахим хуудас, мессеж модем ашиглан тухай бүрд авч байх боломжийг бүрдүүлэх, цаг хүндэрсэн үед өргөн хэрэглээний бараа, төрийн болон хүн эмнэлгийн үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүрд	Ажлын хэсэг
5. Сумын ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай газар дээр нь танилцаж айл өрх бүртэй танилцаж үнэлгээ дүгнэлт өгөх	Тухай бүрд	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
<b>Хоёр: Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах талаар</b>		
2.1 Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар		
1. 2021 оны 08 дугаар сарын 20-аас эхлэн хадлан тэжээл бэлтгэх бололцоотой аж ахуй нэгж, иргэд, малчдын хүчийг хадлан тэжээл бэлтгэх ажилд чиглүүлэх малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөцийн мэдээг малчин өрхийн нэрээр нарийвчлан гаргах	10-р сарын 15- ны дотор	Б3Дарга нар , ХАА-н тасаг
2. Шинээр гаргаж буй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж буй аж ахуй нэгжийн		

ажлын явц чанарт тавьж, гаргаж дууссан нөхцөлд орон нутгийн өмчид бүртгэн авч, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлд албан ёсоор гэрээгээр эзэмшиүүлэх зэргээр хүн малын усан хангамжийг нэмэгдүүлэх	3-р улиралд	Сумын ЗДТГ,ХАА-н тасаг
3. Намрын ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, хүн хүчээр хангаж, хамтран ажиллах	4-р улиралд	Сумын ЗДТГ,ХАА-н тасаг
4. Отроор өвөлжиж, хаваржих малчин өрхийн судалгааг гаргаж малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх	3, 4-р улиралд	ХАА-н тасаг,БЗДарга нар
5. Хээлтүүлэгч малд намрын ангилалтын ажлыг зохион байгуулж ээмэгжүүлж бүртгэлжүүлэх, бруцеллёзын шинжилгээнд хамруулан хээлтүүлэгч малын хүрэлцээ хангамжыг судлан, стандартад тэнцсэн хээлтүүлэгчээр хангах	Тухайн хугацаанд нь.	Сумын МЭТ, ХАА-н тасаг
6. 2021-2022 онд өвөлжих болон хэрэгцээлэх малыг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан аймаг,сумын хэмжээнд тоог нэгтгэн боломжит хэмжээгээр сумын нийт малын 10-осс доошгүй хувь буюу 24662 толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах	Тухай бурд	Сумын ЗДТГ, МЭТ,ХААТ
7. Намрын графикт тарилга, туулгалт, угаалга, боловсруулалтыг технологит хугацаанд нь хийж шаардлагатай мал сүргийг бүрэн хамруулах, өсвөр охин төлд /хурга, ишиг, тугал/ бруцеллёзын вакцин тарих	10-р сарын 15-ны дотор	ХАА-н тасаг, Гонир, Гуа харз МЭҮН